



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/39

Номгон

“Эрүүл мэндийн газрын бүтцийг шинэчлэн”  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 зүйлийн 11.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 89 дүгээр “Татан буулгах комисс байгуулах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/37, А/38 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын бүтцийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Эрүүл мэндийн газрыг шинэчлэгдэн батлагдсан бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) -т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Эрүүл мэндийн газрын бүтцийг шинэчлэн батлах тухай” А/513 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

642310102



Аймгийн Засаг даргын ~~хууль~~ <sup>онь</sup> дүгээр сарын 23-ны өдрийн  
А/39-дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

### АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ





Аймгийн Засаг даргын ~~байр~~ / дүгээр сарын ~~23~~ -ны өдрийн  
 А/ЗЗ... дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

**АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

**Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний алба**

1. Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
2. Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан эмч
3. Нөхөн үржихүй, өсвөр үе залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
4. Ахмад настан, биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан арга зүйч
5. Орчны эрүүл мэнд, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан эмч

**Халдварт бус өвчний тандалт сэргийлэлтийн алба**

1. Халдварт бус өвчний асуудал хариуцсан эмч
2. Хавдрын эрт илрүүлэг, осол гэмтлийн тандалт, сэргийлэлт хариуцсан эмч
3. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан хоол зүйч
4. Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан нийгмийн эрүүл мэндийн ажилтан

**Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн алба**

1. Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан эмч
2. БЗДХ, сүрьеэгийн тандалт сэргийлэлт хариуцсан эмч
3. Дархлаажуулалтын нөөц, вакцин биобэлдмэлийн аюулгүй байдал, голомтын ариутгал халдваргүйтгэл хариуцсан бага эмч

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ХЭЛТЭС**

1. Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
2. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, халдварын асуудал хариуцсан эмч
4. Эх, нярайн тусламж үйлчилгээ хариуцсан эмч
5. Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан эмч
6. Сувилахуйн тусламж үйлчилгээний асуудал хариуцсан арга зүйч
7. Эм, эмнэлгийн хэрэгсэл вакцин биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал хариуцсан эм зүйч
8. Яаралтай тусламж, гамшгийн үеийн асуудал хариуцсан эмч
9. Уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээ хариуцсан эмч

**УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН ХЭЛТЭС**

1. Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга
2. Салбарын төсвийн төлөвлөлт, санхүүгийн бүртгэл мэдээлэл, тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн
3. Байгууллагын ерөнхий нягтлан бодогч
4. Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
5. Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт, хөрөнгийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
6. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
7. Эм, эмнэлгийн хэрэгсэл вакцин биобэлдмэлийн хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
8. Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
9. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
10. Мэдээллийн технологи, зайн оношилгоо хариуцсан мэргэжилтэн
11. Эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан бага эмч

**Нийтлэг үйлчилгээний алба**

12. Архив, бичиг хэргийн ажилтан
13. Даргын туслах
14. Нярав
15. Жолооч – 3
16. Үйлчлэгч – 2
17. Жижүүр – 3

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС**

1. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч (Орчин, хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн асуудал хариуцсан)
2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын асуудал хариуцсан)
3. Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч
4. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч (Халдвар судлалын хяналтын асуудал хариуцсан)